



## МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,  
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,  
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,  
Цахим хуудас: http://www.mof.gov.mn

2024. 04. 17 № 03/2786  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Гомдол хянасан тухай

Танай байгууллагаас зарласан МИАТ/20240102010 дугаартай “Зорчигчийн үйлчилгээний аяллын иж бүрдэл, нэг удаагийн хөнжил” нийлүүлэгчийг сонгох тендер шалгаруулалтын 2 дугаар багцад оролцсон “Бэйссан” ХХК-аас гаргасан гомдлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн 59 дүгээр зүйлийн 59.8 дахь хэсэг болон Сангийн 2023 оны А/253 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам” (цаашид “журам” гэх)-д заасны дагуу захиалагчаас ирүүлсэн холбогдох баримт материалд үндэслэн хянан үзлээ.

“Бэйссан” ХХК-ийн гомдолд захиалагчийн гэрээ байгуулах эрх олгосон “Мая хотелс” ХХК-ийн ирүүлсэн тендер нь тендер шалгаруулалтын баримт бичгийн холбогдох шаардлагад нийцээгүй байх тул захиалагчийн шийдвэрийг хянаж өгөхийг хүссэн байна.

Гомдолд дурдсаны дагуу захиалагчийн гэрээ байгуулах эрх олгосон “Мая хотелс” ХХК-ийн ирүүлсэн тендерийг хянан үзлээ.

1.Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 20.1-д “Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэх эсэх: “Тийм” -FAR25 сертификат /Нэг удаагийн хөнжлийн хувьд/” гэж, техникийн тодорхойлолтод “Бусад шаардлагууд: Тухайн бүтээгдэхүүн дээр FAR 25 сертификаттай байх ба эрүүл ахуйн шаардлага хангасныг нотлох тохирлын гэрчилгээ эсвэл Үндэсний итгэмжлэлийн төвийн итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний бичгийг ирүүлнэ.” гэж тус тус заасан байна.

“Мая хотелс” ХХК-аас аяллын зориулалттай хөнжилд “SGS-CSTC Standards Technical Services Co., Ltd. Xiamen Branch” компаниар хийлгэсэн 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн ХМНЛ2403001157CW дугаартай шинжилгээний хариуг тендерт хавсаргаж ирүүлснийг дээр дурдсан тендер шалгаруулалтын баримт бичигт заасан FAR 25 сертификатын шаардлага хангасан гэж хянан үзсэн захиалагчийн шийдвэр үндэслэлтэй байна.

Аяллын зориулалттай хөнжилд шинжилгээ хийлгэх хүсэлтийг “Мая хотелс” ХХК-аас гаргасан байх бөгөөд уг шинжилгээний хариунд хөнжил үйлдвэрлэгч “Xiamen Kairunair Commodity Co., Ltd” компанийн нэр дээр биш “Мая хотелс” ХХК-ийн нэр байгаа нь үйлдвэрлэгч FAR25 сертификат шаардлага хангахгүй тухай гомдол үндэслэлгүй байна.

2.Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 18.1-д “Ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагыг нотлох гэрээний туршлагын шаардлага: “Шаардлагатай.” гэж, өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 20.1-д “Оролцогчийн туршлагыг харуулах өгөгдлийн хүснэгтэд заасан хугацаанд гүйцэтгэсэн ижил төстэй бараа нийлүүлсэн, үйлчилгээ үзүүлсэн гэрээний талаар V бүлгийн Маягт 3, Маягт 5-ын дагуу бэлтгэсэн мэдээлэл; -Сүүлийн 3 жил буюу 2021, 2022, 2023 онуудын аль нэг жилийн туршлагын мэдээлэл, гэрээний хуулбар, гэрээ дүгнэсэн актын хамт ирүүлнэ!” гэж заасан байна.

“Мая хотелс” ХХК-аас “Монголын иргэний агаарын тээвэр” ТӨХК-тай 2022 онд байгуулсан 22/248 дугаартай зорчигчийн үйлчилгээний аяллын иж бүрдэл худалдах, худалдан авах гэрээ, гэрээ дүгнэсэн актыг тендерт ирүүлсэн нь дээр дурдсан өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 20.1-д заасан шаардлагад нийцсэн гэж хянан үзсэн захиалагчийн шийдвэр үндэслэлтэй байна.

Тендер шалгаруулалтын баримт бичигт ижил төстэй барааны туршлагад аяллын хөнжил гэж заагаагүй байх тул “Мая хотелс” ХХК-аас тендер шалгаруулалтын 1 дүгээр багцад заасан аяллын иж бүрдэлтэй ижил төрлийн бараа нийлүүлсэн туршлага шаардлага хангахгүй тухай гомдол үндэслэлгүй байна.

Иймд тендер шалгаруулалтыг хуульд заасан журмын дагуу цааш үргэлжлүүлэх нь зүйтэй байна.

Хуулийн 59 дүгээр зүйлийн 59.7 дахь хэсэгт заасны дагуу захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилтийг түдгэлзүүлсэн шийдвэрийн хугацаа үүгээр дуусгавар болно.

Хувийг: “Бэйссан” ХХК-д.

ТӨРИЙН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА



Ж.ГАНБАТ